

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР



БАЙГУУЛЛАГЫН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2022 ОН

АГУУЛГА

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН.....	3-7
Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2021-2025 оны хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, түүний хэрэгжилт	
ХОЁР. ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН	8-10
ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	11-36
Дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хүрээнд хийсэн ажлын хүрээнд:	
3.1 Захиргааны дотоод ажлын чиглэлээр	
3.2 Нийслэлийн засаг захиргааны байруудын инженерийн байгууламжийн ашиглалт, ус дулаан цахилгааны хэвийн, найдвартай ажиллагааг ханган ажиллах чиглэлээр	
3.3 Нийслэлийн Засаг захиргааны байруудын цэвэрлэгээ, үйлчилгээ, эрүүл ахуйд нийцсэн зоогийн үйлчилгээ, хурлын заалны ашиглалт, үйлчилгээний чиглэлээр	
ДӨРӨВ.БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ	37-38
ТАВ. БУСАД ЦАГ ҮЕИЙН АЖЛЫН ХЭРЭГЖИЛТ.....	39-43
ЗУРГАА. ДҮГНЭЛТ.....	44

НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 16

Улаанбаатар хот

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2021-2025 оны хөгжүүлэх үндсэн чиглэл, байгууллагын дүрмээр хүлээсэн үүргийн хүрээнд байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг дарга түүний Тамгын газар, Захирагчийн ажлын алба, Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудад чанар стандартад нийцсэн нийтлэг үйлчилгээг үзүүлж, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төрийн албан хаагчдын ажиллах тав тухтай орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа.

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар нь 2022 онд удирдах төрийн захиргааны албан хаагч 1, төрийн үйлчилгээний нийт 454 ажилтан, албан хаагчийн орон тоотойгоор нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчдад үзүүлэх төрийн үйлчилгээний чанар стандартад нийцсэн нийтлэг үйлчилгээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус газар нь нийслэлийн Засаг даргын 2021 оны А/1059 дүгээр захирамжийн дагуу захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс, үйлдвэрлэл, үйлчилгээний алба, инженерийн байгууламжийн, ашиглалт, үйлчилгээний алба гэсэн бүтэцтэйгээр Нийслэлийн засаг захиргааны 1, 2, 3, 4, 5 дугаар байрууд, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 141 дүгээр тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2014 оны “Ухаалаг Улаанбаатар хөтөлбөр батлах тухай”, 2015 оны “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв байгуулах тухай” 185 дугаар тогтоолын дагуу байгуулагдсан Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн Дүнжингарав, Мишээл, Драгон, Оргил салбарууд, Баянхошуу, Сэлбэ дэд төвүүд, Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор байрны цэвэрлэгээ, үйлчилгээ, байр ашиглалтыг хариуцан ажиллаж байна.

Тус байгууллага нь Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч 11 агентлагийн хэмжээнд төрийн үйлчилгээг хэвийн жигд тасралтгүй явуулахад шаардлагатай хөрөнгө, санхүүг төлөвлөн зарцуулах, хөрөнгө материалын ашиглалт, хадгалалтад хяналт тавих, ажил үйлчилгээний төсвийг хянах, хянагдаж батлагдсан төсөв хөрөнгийн төлбөр тооцооны гүйлгээг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэх санхүүгийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

Мөн Хангарди ордны зоогийн газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар театр, Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор байранд байрлах цайны газрууд нь төрийн албан хаагчдад зориулсан өдөр тутмын зоог, хүлээн авалтыг технологийн дагуу гүйцэтгэн үзүүлж байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2021-2025 оны хөгжүүлэх үндсэн чиглэлд нийцүүлэн нийслэлийн захиргааны байгууллагууд, төрийн албан хаагчдад үйлчилгээ үзүүлэх нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус байгууллагад тусгайлан заасан бодлогын баримт бичгийн заалт байдаггүй тул Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 9 заалт, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2021-2025 оны хөгжүүлэх үндсэн чиглэлийн 4 заалтыг нийцүүлэн, байгууллагын үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж ажиллалаа. Тухайлбал:

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд дараах 9 заалтыг хэрэгжүүлэн ажиллалаа.

1. “Ковид-19” цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого

1.1. Цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.

1.1.1.4. Ариутгал халдваргүйтгэл хийх бодисын нөөц бүрдүүлэх, нийтийн эзэмшлийн гудамж талбай, нийтийн тээврийн хэрэгсэлд цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн ажлыг тогтмол зохион байгуулна.

Цар тахлын нөхцөл байдал суларсан хэдий ч урьдчилан сэргийлэх арга хэмжээг үргэлжлүүлэн, тайлант хугацаанд коронавируст /ковид-19/ цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд Нийслэлийн засаг захиргааны 5-н байр, Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн ийн 4-н салбар, Баянхошуу, Сэлбэ дэд төв, Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор байр, нийт 15 байршлын 61.395 м2 талбайд халдвар хамгааллыг мөрдөн, өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгал, халдваргүйтгэлийг тогтмол хийж гүйцэтгэн, төрийн албан хаагчдыг хэвийн, эрсдэл аюулгүй нөхцөлд ажиллах орчин бүрдүүлж ажиллалаа.

3. Эдийн засгийн бодлого

3.1.4. Төсвийн төлөвлөлтийг боловсронгуй болгох замаар төсвийн алдагдлыг бууруулж, сахилга батыг сайжруулна.

3.1.4.5 Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжинэ.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43-р тогтоол, 2022 оны “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 203-р тогтоолын дагуу хэмнэлтийн зарчмыг хэрэгжүүлэн бүх төрлийн үргүй зардлыг гаргахгүй байхаар төлөвлөн ажиллаж 2022 онд өр, авлагагүй ажиллаж, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулан 10 хувийн хэмнэлт гарган ажиллалаа.

Тайлант хугацаанд Хангарди ордны зоогийн газар, НЗДТГ, Улаанбаатар театр, Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор байрны цайны газруудаар дамжуулан нийтийн хоол, хүндэтгэлийн хүлээн авалт, хурлын цайны завсарлага, катерингийн үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэн ажиллалаа. Байгууллагын зоогийн газруудын хүнсний бараа материалын 90 хувийг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг худалдан авч,

хадгалалтын горимыг мөрдөн төрийн албан хаагчдад эрүүл, чанартай бүтээгдэхүүнээр хоол, зоогийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

4. Засаглалын бодлого

4.1.1. Төрийн байгууллагуудаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй үйлчилгээг “Нэг цонхны үйлчилгээ”-нд шилжүүлэн, төрийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд шуурхай, чирэгдэлгүй үзүүлэх бага зардал, цомхон бүтэц бүхий төрийн үйлчилгээний нэгдсэн төвүүдийг иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн байгуулж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

4.1.1.2 Төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хэрэглээнд бүрэн нэвтрүүлнэ.

Байруудын хурлын заалны захиалгыг цахим хэлбэрээр авч, мэдээллийн ил тод нээлттэй байдал, хэрэглэгчдийн цаг хугацааг хэмнэх зорилгоор холбогдох хөгжүүлэлтийн багтай хамтран нийслэлийн нутгийн захиргааны дотоод удирдлагын www.erp.ulaanbaatar.mn системд “Хурлын заал захиалгын систем” нэртэй нэмэлт цэс оруулж хөгжүүлэлтийг 100 хувь хийж гүйцэтгэн үйлчилгээнд нэвтрүүлэхэд бэлэн болгон хэрэгжилтийг ханган ажиллалаа.

4.1.1.3 Тоон гарын үсгийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хэрэглээнд бүрэн нэвтрүүлж, албан бичгийн харилцааг бүрэн цахимжуулна.

Нутгийн захиргааны байгууллагуудын www.erp.ulaanbaatar.mn дотоод удирдлагын систем "Дижитал Монгол" хөтөлбөрийн хүрээнд цахим хэрэглээг дэмжихээр E-DOC системийн баримт боловсруулалт модулийг ашиглан албан бичгийг цахим хэлбэрээр боловсруулан тайлант хугацаанд нийт 366 албан бичгийг 100 хувь тоон гарын үсгээр баталгаажуулан ажиллалаа.

4.1.2. Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагаанд үйлчилгээний стандартыг нэвтрүүлнэ.

4.1.2.2. “Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвөөр үйлчлүүлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үйлчилгээний стандарт бүхий хүртээмжтэй орчныг бүрдүүлнэ.

Тайлант онд нийслэлийн засаг захиргааны байрууд, дэд төвүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан орц, гарцыг сайжруулах, засварлах, орчин нөхцөлийг бий болгохоор иргэдэд зориулсан тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу бүрэн хийж гүйцэтгэсэн ба нийслэлийн засаг захиргааны 5-р байрны В корпус, нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор байрны А4 - В1 давхрын ариун цэврийн өрөөнүүд, болон Сэлбэ дэд төвд шинээр 2 ариун цэврийн өрөөг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан стандартын дагуу шинэчилж иж бүрэн тоноглон тохижуулж ажиллалаа. Мөн Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор байрны гадна орчны талбайд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан 4 гарцыг стандартын дагуу хийж гүйцэтгүүлсэн.

4.1.4. Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангана.

4.1.4.1. “Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтэд хяналт тавьж төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангуулна.

Тайлант хугацаанд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр гаргаж, төсвийн гүйцэтгэлийг батлагдсан хуваарийн дагуу зарцуулж, шилэн данс, цахим хуудаст тайлан, мэдээг тухай бүр нь байршуулан төсөв санхүүгийн ил тод байдлыг бүрэн ханган НЗДТГ-т хүргүүлж ажиллалаа. Мөн төсвийн гүйцэтгэлийг батлагдсан хуваарийн дагуу зарцуулж, шилэн данс цахим хуудаст 123 төрлийн тайлан, мэдээг тухай бүр нь байршуулан төсөв санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллалаа.

4.2.2. Төрийн байгууллага, албан тушаалтныг авлигын эрдлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангана.

4.2.2.1. “Төрийн албан хаагчдыг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, арга хэмжээ авч урьдчилан сэргийлэх авлига хээл хахууль авсан гэмт хэргийн гаралтын тоог буруулах.

Тайлант хугацаанд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд зааснаар тус газрын хуулийн үйлчлэлд хамраах албан тушаалын 13 албан хаагч Авлигатай тэмцэх газарт ХАСУМ, ХАСХОМ-ийг заасан хугацаанд мэдүүлсэн. Хүндэтгэн үзэх шалтгаанаар хойшилсон болон мэдүүлээгүй, авлига, ашиг сонирхлын зөрчил гаргасан албан хаагч байхгүй байна.

4.2.3. Төрийн албаны хүний нөөцийг чадавхжуулж, төрийн албан хаагчийн сургалтын байгууллагын материаллаг орчныг сайжруулж, орчин үеийн шаардлагад нийцсэн сургалтын орчин, дэд бүтэц бий болгоно.

4.2.3.1. “Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Сургалт, судалгааны төвийн төвийн үйл ажиллагааг бэхжүүлэх, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтуудад хамруулна.

Тайлант онд ажилтан, албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, тогтвор суурьшлыг хангах үүднээс нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын ажилтан, албан хаагчдад 2022 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг батлуулж, эхний хагас жилийн байдлаар нийт 18 сургалтад давхардсан тоогоор 539 ажилтан, албан хаагч хамрагдсан. Мөн дээд газраас болон бусад байгууллагаас зохион байгуулагдсан 61 удаагийн сургалтад давхардсан тоогоор 814 албан хаагчийг ажил үүргийн чиглэлийн дагуу хамруулсан.

5. Ногоон хөгжлийн бодлого

5.2.6. Бохирдож доройтсон, үржил шимээ алдсан хөрсийг нөхөн сэргээх хүн амын эрүүл мэндийг хамгаалах, салбар дундын уялдааг хангасан нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх “Хөрсний бохирдолгүй хот” арга хэмжээг хэрэгжүүлнэ..1. Ногоон байгууламж бүхий хот

5.2.6.2. Хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээ боловсруулж, хэрэгжүүлнэ.

Нийслэлийн өнгө үзэмжийг нэмэгдүүлэхэд бид өөрсдийн эрхэлж буй үйл ажиллагааны хүрээнд хүрээлэн буй орчны агаарыг цэвэршүүлж, чийгшүүлэх, шороо тоосжилт, агаар дахь хорт элементүүд, түүний дотор өвчин үүсгэгч нян, бактериудыг бууруулах, дархлааны системийг бэхжүүлэх, төрийн албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах үүднээс Нийслэлийн засаг захиргааны 5-н байр, Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн 4-н салбар, Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн нийтийн эзэмшлийн гадна талбайд хаврын цэцэгжүүлэлт, ногоон байгууламж, тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Тус газар нь төрийн албан хаагчдыг эко орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд үйлчилгээ, техникийн ажилчдын оролцоог нэмэгдүүлэхээр “Ногоон орчин” сэдэвт албан тасалгааг цэцэгжүүлэх болзолт уралдааныг зохион байгууллаа. Аяны хүрээнд ажилчид идэвх санаачилгатай оролцож 300 гаруй төрлийн 400 цэцгийг нэмэгдүүлсэн.

Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2021-2025 оны хөгжүүлэх үндсэн чиглэлийн дараах 3 заалтыг хэрэгжүүлэн ажиллалаа.

5. Засаглал

5.3. Мэргэшсэн, чадварлаг иргэндээ үйлчилдэг, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ.

5.3.1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад болон олон улсын чанарын менежментийн тогтолцоо, стандартыг нэвтрүүлсэн байна.

Тайлант хугацаанд Стандарт хэмжил зүйн газраас шинээр батлагдсан “Хүнсний бүтээгдэхүүний илчлэг тодорхойлох арга MNS 6958:2021”, “Хүнсний вирусийн бохирдлыг багасгах, сэргийлэхэд хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчмуудыг ашиглах удирдамж MNS GL79:2021” стандартуудыг холбогдох зоогийн газрын ажилчдад танилцуулж мэдээлэл олгон ажиллалаа. Олон улсын чанарын менежментийн тогтолцоо “ISO9001:2016, MNS ISO 19091” стандартыг үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр 2023 оны төсөвт оруулж суулгасан болно.

5.3.2. Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.

Байгууллагад мөрдөгдөж байгаа “Нутгийн захиргааны байгууллагуудын цэвэрлэгээ үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага” UCS0201B:2020 удирдамж арга зүйн баримт бичгийг шинээр ажилд орсон буюу үйлчилгээний ажилтнуудад танилцуулах сургалтыг тухай бүрд нь зохион байгуулж ажиллалаа.

Тайлант оны 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Дорноговь аймгийн нийтлэг үйлчилгээний газрын хамт олон, Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын Аж ахуйн тасгийн хамт олонд 2022 оны 03 сарын 14-ний өдөр тус тус UCS0202B:2020 "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын цэвэрлэгээ, үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага" удирдамж арга зүйн баримт бичгийг танилцуулан сурталчилж

ажиллалаа. Мөн 2022 оны 12-р сарын 12-ны өдөр шинээр ажилд орсон нийт 68 үйлчилгээний ажилчдад стандартыг танилцуулах сургалтыг зохион байгуулсан.

5.5. Шударга ёсыг эрхэмлэн бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлийн гэмт хэргийг буруулна.

5.5.1 Шударга, хариуцлагатай, ил тод, нийтийн албыг бэхжүүлж, авлига, хээл хахуулийн бүх хэлбэрийг таслан зогсоож, хяналтыг нэмэгдүүлнэ.

Тус газрын хэмжээнд 2022 онд хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллан, хэрэгжилтийг заасан хугацаанд нь буюу нийт 2 удаа хүргүүлэн ажилласан. Байгууллагын хэмжээнд хэрэгжүүлж буй авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд хүний нөөцийн ил тод байдал, төсөв санхүүгийн ил тод байдал, үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, шилэн данс вэб хуудаст 17 төрлийн тайлан, мэдээг 123 удаа, байгууллагын цахим хуудас болон “Шударга, ёс хөгжил дэвшилд” мэдээллийн самбарт тогтмол байршуулсан. Тайлант хугацаанд ашиг сонирхлын зөрчил гаргасан ажилтан, албан хаагч байхгүй болно.

5.5.2 Төрийн байгууллага, албан тушаалтныг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангана.

Тайлант хугацаанд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд зааснаар тус газрын хуулийн үйлчлэлд хамраах албан тушаалын 13 албан хаагч Авлигатай тэмцэх газарт заасан хугацаанд ХАСУМ, ХАСХОМ-ийг мэдүүлсэн. Хүндэтгэн үзэх шалтгаанаар хойшилсон болон мэдүүлээгүй, авлига, ашиг сонирхлын зөрчил гаргасан албан хаагч байхгүй байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Хууль тогтоомж, НИТХ-ын тогтоол, нийгэм эдийн засгийн зорилт, Нийслэлийн Засаг даргын захирамж, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийн явц үр дүнг тайлагнаж ажиллах

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 дугаар захирамжаар баталсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын дагуу тайлант хугацаанд нийт 32 төрлийн захирамжлалын баримт бичгийн 50 зүйл заалтын хүрээнд тайлан мэдээг бэлтгэж, сар улирлаар 1-4 удаагийн давтамжтайгаар заасан хугацаанд www.monitoring.ulaanbaatar.mn цахим сайтад байршуулахын зэрэгцээ Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст цахим болон цаасан суурьтайгаар хүргүүлж ажиллалаа. Тодруулбал:

Хүснэгт 1

Д/д	Захирамжлалын баримт бичгийн төрөл	Захирамжлалын баримт бичгийн тухай	Хамаарах зүйл заалт	Тайлан өгсөн давтамж
1.	Монгол Улсын хууль	1. Төрийн албаны тухай	1	
		2. Хөдөлмөрийн тухай хууль	3	
		3. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай	1	1
		4. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай	1	
		5. Төрийн хэмнэлтийн тухай хууль	2	1
2.	Засгийн газрын тогтоол	6. Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай /№2018-258/	7	1
		7. Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай /№2022-07/	5	1
		8. Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай /№2022-192/	1	
		9. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай /№2022-203/	1	1
		10. Журам шинэчлэн батлах тухай /№2020-206/	1	
		11. Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /№2021-374/	1	
		12. Журам батлах тухай /№2022-201/	1	
3.	Монгол Улсын Ерөнхий сайдын албан даалгавар	13. Цахим шилжилтийг эрчимжүүлэх тухай /№2022-03/	2	1

4.	Нийслэлийн Засаг даргын захирамж	14. “Журам батлах тухай” /№2015-А/633/	1	
		15. “Журам шинэчлэн батлах тухай” /№2021-А/52/	1	
		16. “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай”/№2021-А/115/	1	
		17. “Нийслэлийн 2020-2021 оны өвөлжилтийн дүн, 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл хангах тухай” №2021-А/382/	1	
		18. “2022 оныг Хотын иргэний жил болгон зарлах тухай” /№2022-А/01/	2	4
		19. “Дүрэм шинэчлэн батлах тухай” /№2022-А/93/	1	1
		20. “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг цуцалсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай ” /№2022-А/180/	2	
		21. “Ажлын хэсэг байгуулах тухай” /№2022-А/578/	1	1
		22. “Нийслэл хотын ялгамж чанарыг илтгэх тэмдгийг батлах тухай” /№2022-А/768/	1	
		23. “Хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” /№2022-А/789/	1	1
		24. “Журам шинэчлэн батлах тухай” /№2022-А/1049/	1	2
		25. “Журам шинэчлэн батлах тухай” /№2022-А/1106/	1	2
		26. “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” /№2022-А/1357/	1	10
5.	Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын тэмдэглэл	27. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2022 оны 02 дугаар хуралдааны тэмдэглэл	2	4
		28. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2022 оны 20 дугаар хуралдааны тэмдэглэл	2	1
6.	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол	29. Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай /№2020-02/09/	1	1
		30. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай /№2020-02/10/	1	1

7.	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоол	31. Журам батлах тухай /№2020-02/09/	1	4
		32. Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн хүртээмжийг сайжруулах тухай /№2021-210/	1	4
Нийт		32	50	42

2.2 Нийслэлийн Засаг даргын захирамж, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын албан даалгаврын 3 төрлийн захирамжлалын баримт бичгийн 12 заалтын хэрэгжилтийн мэдээг сар бүр 2-4 удаагийн давтамжтай хүргүүлж ажилласан. Тодруулбал:

Хүснэгт 2

№	Агуулга	Тайлан хүргүүлсэн давтамж
1	Хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх тухай	4
2	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 02 дугаар хуралдааны тэмдэглэлд	4
3	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 01 дугаар хуралдааны тэмдэглэлд	2
4	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 01 дугаар хуралдааны тэмдэглэлд	4
5	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 01 дугаар хуралдааны тэмдэглэлд	4

Тайлант онд хяналтад авсан Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл өмнөх оны мөн үеэс 3 заалтаар буурч, захирамжлалын баримт бичгийн тоо 6 төрлийн нэмэгдэж, хамаарах зүйл заалтын тоо 10 заалтаар буурсан үзүүлэлттэй байна.




График 1. Захирамжлалын баримт бичгийн тоон өмнөх онтой харьцуулсан байдал

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд:

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар нь Нийслэлийн Засаг даргын 2016 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А/666 дугаар “Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын дүрэм шинэчлэн батлах тухай” захирамжаар батлагдсан дүрэмд тусгасан дараах 7 үндсэн чиг үүргийн дагуу Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын алба, хэрэгжүүлэгч агентлагууд болон Нийслэлийн Засаг захиргааны байруудад байрлан ажиллаж байгаа төрийн албан хаагчдын ажиллах ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

3.1 Захиргаа, дотоод ажлын чиглэлээр

Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг эдийн засаг, нийгмийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн холбогдох заалтуудад нийцүүлэн 2022 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд үйлчилгээ, техникийн ажилтнуудын оролцоог нэмэгдүүлж, шинэ санал санаачилгыг дэмжин, идэвхжүүлэн ажиллаж байна.

3.1.1 Хүний нөөцийн чиглэлээр:

Хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлээр Баянгол дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсээс 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан “Бүтээлч Баянголчууд” хөдөлмөр эрхлэлтийг дэмжих өдөрлөг, Нийслэлийн хөдөлмөр, халамжийн газар, 9-н дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэстэй хамтран 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулсан “Ажилтай орлоготой залуус” өдөрлөг, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Нийслэлийн хөдөлмөр, халамжийн газрын хамтран 2022 оны 11 дүгээр сарын 28-ний өдөр зохион байгуулсан “Эх орондоо хөдөлмөрлөх боломж 2022” хөдөлмөр эрхлэлтийг дэмжих өдөрлөг, Сүхбаатар дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс Хөгжлийн шийдвэл ТББ-тай хамтран 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулсан “Ажил олгогчдын уулзалт” форумд тус тус оролцсон. Мөн Барилгын политехникийн коллежид 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдөр, НҮНТ-ийн Дүнжингарав салбарын гадна талбайд 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдөр, Хан-Уул дүүргийн 16 дугаар хороонд байрлах Хаан банкны гадна талбайд 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр тус тус нээлттэй ажлын байрны өдөрлөгийг зохион байгуулж, байгууллагын чиг үүрэг, үндсэн үйл ажиллагаа танилцуулан сурталчилж ажлын байрны сул орон тоог нээлттэй зарлан ажилласан.

Мөн ажлын байрны сул орон тоог байгууллагын цахим хуудас www.khangardi.mn болон зарын нэгдсэн цахим хуудас www.unegui.mn, www.biznetwork.mn, байгууллагын мэдээллийн ил тод байдлын самбарт тухай бүр байршуулж нийтэд мэдээлэхийн зэрэгцээ ажлын байрны зарыг Хөдөлмөр эрхлэлтийн газар болон дүүргүүдийн Хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтэст хүргүүлэн ажиллалаа. Тайлант хугацаанд 17 ажлын байрны 120 сул орон тоонд 150 ажил горилогч материалаа ирүүлж, нөөцөд бүртгэгдсэн. Нөөцөд бүртгэгдсэн төрийн албан хаагчийн анкетаас сонгон шалгаруулалт хийж, 92 иргэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулсан.

Тайлант онд байгууллагын 270 ажилтан, албан хаагчдын хувийн хэргийн бүрдлийг ханган баяжуулалт хийж ажилласан ба ажлын байрны сул орон тоонд зохих шаардлагыг хангасан 13 ажилтныг албан тушаалд дэвшүүлэн томилсон байна.



Зураг 1. Нээлттэй ажлын байрны өдөрлөгийн үеэр

Тайлант хугацаанд цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан ажилтан, албан хаагчдын судалгааг тухай бүр гарган холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэн ажилласан. Тухайлбал:

1. Төрийн захиргааны эрхэлсэн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчийн сургалтын;
2. Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим систем дэх төрийн албан хаагчийн нэгдсэн тоо бүртгэлийн;
3. Жирэмсэн, хүүхэд асрах чөлөөтэй байгаа ажилтан, албан хаагчдын;
4. Байгууллагын 0-15 насны хүүхэдтэй ажилтан, албан хаагчдын;
5. Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын;
6. Ажилтан, албан хаагчдын оршин суугаа хаягийн;
7. Байгууллагын ахмад настнуудын;
8. Ажилтан, албан хаагчдын орон сууцны нөхцөлийн;
9. Шинээр ажилд томилогдсон ажилтан, албан хаагчдын;
10. Хугацаат цэргийн алба хаасан ажилтан, албан хаагчдын;
11. Цалин хөлсний бүтцийн;
12. Эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан албан хаагчдын;
13. Ажилтан, албан хаагчдын шинээр төрсөн хүүхдийн;
14. Ажилтан, албан хаагчдын шагналын

судалгааг тус тус гаргасан.

Мөн байгууллагад үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай олон жил ажилласан ажилтан, албан хаагчдыг дараах байдлаар шагналд тодорхойлсон. Үүнд: Төрийн дээд одон медальд 5, МУ-ын Засгийн газар, яамдын шагналд 21, ТЗҮЭГазрын шагналд 2, НИТХ-ын шагналд 24, НЗД-ын шагналд 67 нийт 119 ажилтан, албан хаагчийн тодорхойлолтыг хүргүүлж, шагнаж урамшуулсан.

3.1.2 Сургалт зохион байгуулсан талаар:

Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, тогтвор суурьшлыг хангах үүднээс Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын 2022 онд ажилтан, албан хаагчдад зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг баталсан ба тус төлөвлөгөөнд 20 арга хэмжээ төлөвлөснөөс 18 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, давхардсан тоогоор 539 ажилтан, албан хаагчийг сургалтад хамруулсан. Тус төлөвлөгөөний хэрэгжилт 90%-ийн биелэлттэй байна. Мөн дээд газраас болон бусад байгууллагаас зохион байгуулагдсан 61 удаагийн сургалтад давхардсан тоогоор 814 албан хаагчийг ажил үүргийн чиглэлийн дагуу хамруулсан.

Байгууллагын хэмжээнд 2022 онд ажлын бус цагаар өөрийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэн Удирдлагын академийн Удирдахуйн Ухааны Их Сургуульд төрийн

удирдлагын докторант 1, Санхүү, эдийн засгийн их сургуульд бизнесийн удирдлагын магистрант 1, Засагт хан дээд сургуульд төрийн захиргаа удирдлагаар магистрт 1, ХААИС-ийн газар зохион байгуулалтын бакалаврт 1, Олон Улсын Эдийн Засаг Бизнесийн Их Сургуульд нягтлан бодох бүртгэлээр бакалаврт 1 нийт 5 албан хаагч хувийн зардлаараа суралцаж байна.




График 2. Өмнөх онуудын мөн үетэй харьцуулсан байдал



Зураг 2. Сургалтын үеэр

Байгууллагын мэдээллийн цагийг 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Баянзүрх дүүргийн Онцгой байдлын газартай хамтран зохион байгуулж “Гамшгаас хамгаалах, галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, гамшгаас хамгаалах гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдал болон Газар хөдлөлт”, “Эрт илрүүлгийн урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүл зөв хооллолт” сэдвээр, 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Нийслэлийн Гэр бүл, хүүхэд залуучуудын газар, Сэтгэлийн боловсролын төв ТББ-тай хамтран зохион байгуулж “Стресс менежмент”, “Эцэг эх, хүүхдүүдийн хоорондын харилцаа” сэдвээр тус тус мэргэжлийн зөвлөгөө мэдээллийг өгч ажиллалаа.



Зураг 3. Мэдээллийн цагийн сургалтын үеэр

3.1.3 Тушаал шийдвэрийн талаар:

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гаргасан тушаал 48, Байгууллагын хүний нөөцийн чиглэлээр гаргасан тушаал 406 тус тус батлагдан гарч хэрэгжилтийг ханган ажилласан болно.




График 3. Сүүлийн 5 жилийн тушаалын тоог харьцуулсан байдал

3.1.4 Өргөдөл гомдлын талаар:

Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдаас хөдөлмөрийн харилцаатай холбоотой нийт 252 өргөдөл ирснийг холбогдох хууль, журмын дагуу хугацаанд нь бүрэн шийдвэрлэж хариуг өргөдөл гаргагчид танилцуулсан. Өргөдөл гомдлын бүртгэл, явц болон шийдвэрлэлттэй холбоотой ямар нэгэн зөрчил гараагүй, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа тогтмол шинжтэй байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног, 15 цаг, 11 минут байна.

Сүүлийн 5 жилийн хугацаанд өргөдөл, гомдлын тоо тогтмол буурсан боловч 2017 оны мөн үетэй харьцуулбал 15 хувиар буурч, 2021 оноос 38 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Тайлант онд ажлын байрны хүний нөөцийн хомсдол үүссэнээс ажил хавсран гүйцэтгэх хөдөлмөрийн хөлстэй холбоотой өргөдөл 78, ажилд орох, чөлөөлөгдөхтэй холбоотой өргөдөл 91 буюу нийт өргөдлийн 67 хувийг үүсгэсэн байна. Жишээлбэл, шинээр нийт 92 ажилтан, албан хаагч ажилд орсны 28 хүн буюу 30.4 хувь нь ажилд ороод удалгүй ажлаас чөлөөлөгдөж, тогтвор суурьшилгүй байсантай холбоотой гэж үзэж болно. Мөн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа өссөн нь үүнтэй холбоотой.



График 4. Өргөдөл гомдлын тоог өмнөх онуудтай харьцуулсан байдал

Тайлант хугацаанд ирсэн өргөдлийг ангилан авч үзвэл:

- Хөдөлмөрийн хөлстэй холбоотой өргөдөл - 78
- Захиргааны чөлөө хүссэн өргөдөл - 32
- Ажилд орох, чөлөөлөгдөхтэй холбоотой өргөдөл - 91
- Жирэмсний болон хүүхэд асрах чөлөө хүссэн өргөдөл - 20
- Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай өргөдөл - 22
- Ажилд шилжих, дэвшин ажиллах тухай өргөдөл - 5
- Бусад - 4




График 5. Ирсэн өргөдлийг төрлөөр ангилан харуулав

3.1.5 Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар:

Нийслэлийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/252 дугаар захирамж “Нийслэлийн байгууллагуудын хэмжээнд дагаж мөрдөх албан хэрэг хөтлөлтийн ажлын нийтлэг журам”, газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/16 тушаалаар баталсан “Албан хэрэг хөтлөлтийн ажлын зохион байгуулалтын журам”-ыг тус тус байгууллагын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажиллалаа.

Тайлант хугацаанд нийт ирсэн албан бичиг 391 үүнээс хариутай бичиг 108, хариугүй 254 бичиг хүлээн авч холбогдох хэлтэс, албадад шилжүүлэн, шийдвэрлэлтэд хяналт тавин ажилласан.

Ирсэн албан бичгийг хэлтэс, албадаар нь ангилан хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3

№	Төрөл	Ирсэн бичгийн тоо	Ирүүлсэн хэлбэр			Шийдвэрлэлт					Шийдвэрлэлтийн дундаж хоног	
			Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвөөр бүртгэгдсэн бичгийн тоо	Байгууллагаар бүртгэгдсэн бичгийн тоо	Системээр бүртгэгдсэн бичгийн тоо	Хариутай бичгийн тоо	Хариугүй бичгийн тоо	Хугацаандаа хаасан	Шийдвэрлэлтийн шатанд байгаа бичиг	Хугацаа хэтэрсэн бичиг		Нийт ирсэн бичгийн шийдвэрлэлтийн хувь

1.	Удирдлага	40	0	2	38	11	29	40	0	0	100%	5.33
2.	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс	224	0	19	205	85	139	217	5	1	99.5%	9.02
3.	Инженерийн байгууламжийн ашиглалт, үйлчилгээний алба	109	0	16	93	36	73	104	3	1	98.7%	12.89
4.	Үйлдвэрлэл, үйлчилгээний алба	18	0	4	14	5	13	17	0	1	92%	5.17
5.	Нийт ирсэн бичиг	391	0	41	350	137	254	378	8	3	99.0%	9.54




График 6. Шийдвэрлэлтийн байдлыг өмнөх оны мөн үетэй харьцуулсан байдал

Тайлант хугацаанд нийт 366 албан бичгийг дээд шатны байгууллага, нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, бусад гадны байгууллагад албан бичгийн стандарт, дүрэм, зааврын дагуу боловсруулж хүргүүлсэн ба Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба, Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар, Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвөөс холбогдох газруудад явуулсан нийт 6239 албан бичгийг тус газрын 2 бичиг хүргэгч шуурхай хүргэж ажиллалаа.

Тайлант онд иргэд, байгууллагын хүсэлтийн дагуу нийт 80 баримтад лавлагаа олгож, хуулбар үнэн тэмдэг дарж, бүртгэл хөтөллөө.

Явсан албан бичгийг хэлтэс, албадаар нь ангилан хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4

№	Төрөл	Явсан бичгийн тоо	Хариутай бичгийн тоо	Хариугүй бичгийн тоо	Хугацаа хэтрүүлж харуу	Шийдвэрлэх шатандаа	Хугацаа хэтэрсэн, харил илээгүй	Шийдвэрлэл -ТИЙН ХУВЬ
1.	Удирдлага	5	0	5	0	0	0	100%
2.	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс	283	0	283	0	0	0	100%
3.	Инженерийн байгууламжийн ашиглалт, үйлчилгээний алба	47	0	47	0	0	0	100%
4.	Үйлдвэрлэл, үйлчилгээний алба	31	0	31	0	0	0	100%
5.	Нийт явсан бичиг	366	0	366	0	0	0	100%

Байгууллагын үйл ажиллагаанаас 2021 онд үүсэж хөтлөгдсөн 210 хадгаламжийн нэгжийг 2022 оны 1 дүгээр улиралд акт үйлдэн хүлээн авснаас байнга хадгалах 35, 70-н жил хадгалах 22, түр хадгалах 153 зэрэг хугацаагаар ангилсан.


2020 оны ХХНЖ-ын дагуу хүлээн авсан баримтын нэгдсэн тоо мэдээ

Хүснэгт 5

Хэлтсийн нэр	Байнга хадгалах	70 жил хадгалах	Түр хадгалах	Тусгай төрөл	ХН-ийн тоо
Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс	55	24	160	-	239
Инженерийн байгууламжийн ашиглалт, үйлчилгээний алба	19	-	7	-	26
Үйлдвэрлэл, үйлчилгээний алба	2	-	9	-	11
Дүн	76	24	176	-	276

Байгууллагын газрын даргын 2020 оны үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гаргасан А/01-64, боловсон хүчний чиглэлээр гаргасан Б/01-21 нийт 335 тушаалыг ArchiveEdoc цахим программд тушаалын тэргүү, агуулга, он цагийн хязгаарыг шивэх, цахим хувийг хавсаргах гэх мэт ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Архивын цахим программд бүртгэгдсэн захирамжлалын баримтад нягтлан шалгалт хийсэн ажлын мэдээ, тайланг Нийслэлийн Архивын газарт илгээсэн.

Төрийн архивд нөхөн бүрдүүлэлт хийхээр байгууллагын архивд 2012 оноос 2020 оны хугацаанд үүссэн байнга хадгалах 298 хадгаламжийн нэгж, дүрс бичлэгийн 8 баримтад эрдэм шинжилгээ техник боловсруулалтын ажлыг хийж гүйцэтгэн бэлтгэж, 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн Нийслэлийн Архивын газрын дэргэдэх Баримт нягтлан шалгах комиссын 03 дугаар хурлаар хэлэлцүүлэн, Төрийн архивд 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдөр шилжүүлсэн.



Зураг 4. Тушаалын цахим хувийг хавсаргасан байдал



Зураг 5. Шилжүүлсэн хадгаламжийн нэгжийг бэлтгэсэн байдал

Тайлант хугацаанд архивын сан хөмрөгийн баримтыг бүрдүүлэх, бүртгэх, хадгалах, хамгаалах, хяналт тавих, ашиглах болон албан хэрэг хөтлөлтийг мөрдөн ажиллахад шаардагдах мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор холбогдох албан хаагчийг Архивын ерөнхий газраас 2022 оны 04 дүгээр сарын 06-ний өдөр зохион байгуулсан “Архив албан хэрэг хөтлөлтийн талаар байгууллагын архив, бичиг хэргийн ажилтнуудын анхаарах асуудал” сэдэвт сургалтад хамруулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 7 дугаар тогтоолын дагуу Монгол хэлний тухай хууль, “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр - III” хэрэгжүүлэх ажлын хүрээнд ойрын хугацаанд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулж, албан бичгийг кирилл болон үндэсний бичгээр хослуулан хөтлөх ажлыг үе шаттайгаар эхлүүлж, 6 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулж, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэн давхардсан тоогоор нийт 95 ажилтан, албан хаагчийг хамруулсан.



Зураг 6. Монгол бичгийн явуулж буй байдал

3.1.6 Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр:

Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, тогтвор суурьшлыг хангах, ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд нийгмийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх, ажиллах таатай нөхцөл бололцоог бүрдүүлж хүний нөөцийн тогтвор суурьшлыг хангаж ажиллалаа. Тухайлбал:

Жил бүрийн аравдугаар сарын 01-ний өдөр тус байгууллагаас гавьяаны амралтад гарсан ахмадуудад хүндэтгэл үзүүлэн хүлээж авдаг уламжлалтай. Тус баярыг тохиолдуулан Нийтлэг үйлчилгээний газрын хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулсан, амжилт үйлсээрээ энэ байгууллагатай салшгүй холбогдсон 70 гаруй ахмад настнуудаа 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр хүндэтгэл үзүүлэн хүлээн авч, гарын бэлэг гардууллаа.



Зураг 7. Ахмадуудад хүндэтгэл үзүүлэх үеэр

Өндөр насны тэтгэвэрт гарсан 7 ажилтанд нэг удаагийн буцалтгүй тусламжид 47,375,817 төгрөг, ар гэрийн гачигдал гарсан 15 ажилтан, албан хаагчид өргөдлийг үндэслэн 15.326,835 төгрөг, цалин хөлсөнд нийт 3,160,920,231 төгрөг, ажилласан жилийн нэмэгдэл болох 151,540,507 төгрөг, илүү цагийн болон ажил хавсран гүйцэтгэсний

нэмэгдэл хөлс 306,679,960 төгрөг, ажилтан, албан хаагчдын хоол, тээврийн зардалд 581,063,100 төгрөг, шинээр хүүхэдтэй болсон ажилтан, албан хаагчдад 2,250,000 төгрөг, гэр бүлийн ёслолд оролцсон 4 ажилтанд 2,000,000 төгрөгийг тус тус олгосон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”, тус газрын “Нэгж, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах, тайлагнах, ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх журам”-ын дагуу 2022 онд нийт давхардсан тоогоор 270 ажилтан, албан хаагчдын гүйцэтгэлийг үр дүнг улирал бүр үнэлж, 245,632,200 төгрөгийн урамшуулал олгон ажилласан.

Газрын даргын 2022 оны А/04, 21, 38, 48 дугаар тушаалаар ажилтан, албан хаагчдын 2021 оны 4 дүгээр улирал, 2022 оны 1, 2, 3 дугаар улирлын ур чадварыг дүгнэж, Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолын дагуу нийт 575,228,600 төгрөгийн ур чадварын нэмэгдлийг сар бүр тооцон олгосон байна.

3.1.7 Эрүүл мэнд, биеийн тамир спортын чиглэлээр:

Монгол Улс даяар нийт хүн амыг 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 1 жилийн турш Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.24 дэх заалт “Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг дэмжиж ажилтан, албан хаагчдыг бүрэн хамруулах, тал дээр хяналт тавин ажиллаж байна.

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг даргын бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2022-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх, эрүүл зөв амьдралын хэв маягийг хэвшүүлж дадал болгохоор “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аяныг 2022 оны 2 дугаар улиралд зохион байгуулсан. Тус аяны хүрээнд байгууллагын ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийг сайжруулах, өвчлөх, цаг бусаар эндэх эрсдэлийг бууруулахаар 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн “Ажлын байрны дасгал хөдөлгөөн” уриатайгаар өглөө ажлын цаг эхлэхээс өмнө, өдөр цайны цагаар нийт 1-2 удаа тогтмол дасгал хөдөлгөөн хийж хэвшүүлээд байна. Биеийн тамир, спортын хамтлагаас байгууллагын хэмжээнд “Хөдөлгөөн-Эрүүл мэнд” явган аяллыг 2022 оны 05 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулж, хөгжөөнт тоглоом болон спорт тэмцээнүүд зохион байгуулсан.



Зураг 8. Явган алхалтын тэмцээний үеэр

Мөн Биеийн тамир спортын үйл ажиллагааг идэвхжүүлэх, хамт олны оролцоо, багийн ажиллагааг нэмэгдүүлэх, тэднийг хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх зорилгоор

2022 оны 04 сарын 23-ны өдөр захиргаа төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн албан хаагчдын дунд боулингийн тэмцээнийг зохион байгууллаа. Нийт 9 багийн 45 тамирчид оролцож хурд хүч авхаалж самбаагаа сорин оролцсон.



Зураг 9. Тэмцээний үеэр

Нийслэлийн Засаг даргын нэрэмжит Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын “Спортын IV наадам” 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 2022 оны 09 дүгээр сарын 18-ны өдрүүдэд 5 төрлөөр зохион байгуулагдсан. Тус тэмцээнд Нийтлэг үйлчилгээний газрын эрэгтэй, эмэгтэй багийн тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорин амжилттай оролцож, эмэгтэй баг тамирчид “Волейбол, Сагсан бөмбөг” төрлүүдэд шалгарч алтан медалийн эзэд болсон бол, эрэгтэй баг тамирчид Волейболоор тусгай байрт шалгарсан.



Зураг 10. Тэмцээний үеэр

3.1.8 Санхүү, аж ахуйн чиглэлээр:

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч 11 агентлагийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээг 7 агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч, 1 тооцооны нягтлан бодогч, 6 агентлаг хариуцсан нярваар дамжуулан иж бүрнээр үзүүлэн ажилласан. Тайлант онд 2021 оны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар аудитын газраас 1 акт, 2 албан шаардлага, 7 зөвлөмж өгсөн. Дээрх үзүүлэлтийг бууруулж ажиллахаар зорилт тавин ажиллаж байна.

Төрийн үйлчилгээг хэвийн жигд тасралтгүй явуулахад шаардлагатай хөрөнгө санхүүг төлөвлөн зарцуулж, хөрөнгө материалын ашиглалт, хадгалалтад хяналт тавин, ажил үйлчилгээний төсвийг хянан, хянагдаж батлагдсан төсөв хөрөнгийн төлбөр тооцооны гүйлгээг цаг хугацаанд нь хийж, төсвийн гүйцэтгэлийг батлагдсан хуваарийн дагуу зарцуулж, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөн ажилласан.

Байгууллагын зоогийн газрын хүнсний бараа материалын 90 хувийг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг худалдан авч, төрийн албан хаагчдад эрүүл, чанартай бүтээгдэхүүнээр хоол, зоогийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах үүднээс www.shilendans.gov.mn цахим хуудаст холбогдох 17 төрлийн тайлан, мэдээг гаргаж, тухай бүр нь буюу тогтоосон хугацаанд нь нийт 123 удаа байршуулан хэрэгжилтийг ханган ажилласан.

Байгууллагын санхүүгийн тайлан мэдээг цаг тухайд нь гарган нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулан ажилласан. PAYROL-Цалингийн программд нийт ажилтан албан хаагчдын цалингийн тооцоо, бүртгэл мэдээллийг сар бүр тушаал шийдвэрийн дагуу хөтөлж, шинэ ажилчдын мэдээллийг бүртгэн, “Төрийн Албаны нэгдсэн систем”-ын цалингийн программд ажилчдын цалингийн тооцооллыг хийж ажиллаж байна. Байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг хангаж, эд хариуцагчийн картын дотоод хөдөлгөөнийг Acolous программд бүртгэлжүүлэн хөрөнгийн шилжилтийг эд хариуцагчид карталсан. Эд хөрөнгийн тооллогыг тайлант онд 2 удаа зохион байгуулж, 8,824139,99 төгрөгийн аж ахуйн бараа материал актлах саналыг холбогдох газарт хүргүүлж шийдвэрлүүлсэн ба эд хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг картаар дамжуулан бүртгэлжүүлж өглөг, авлага үүсгэлгүй ажилласан.

Бараа материал, түлш, шатах тослох материалын тайланг сар бүр гарган, тооцоог НББ-ын үйл ажиллагааг тогтоосон журмын дагуу хөтлөн эд хөрөнгө бараа материалын хадгалалт, хамгаалалт, эмх цэгц, бүрэн бүтэн байдлыг ханган ажилласан. Тайлант хугацаанд агуулахын эд хөрөнгийг тус тус эмхэлж цэгцэлж, ариутгал халдваргүйтгэл, шавжгүйтгэл хийж ажилласан. Тайлант хугацаанд худалдан авах ажиллагаатай холбоотой ямар нэгэн зөрчил, гуравдагч этгээдээс гаргасан гомдолгүй ажиллаа.

3.1.9 Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр:

Тогтоол шийдвэр, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавьж дотоод хяналт шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 дугаар захирамжаар баталсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”, бусад холбогдох дүрэм, журам, баримт бичгийг тус тус удирдлага болгон ажиллалаа.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын талаар:

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, бусад холбогдох дүрэм, журмын дагуу бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд улирал бүр хяналт шинжилгээ, үнэлгээг хийсэн.

Байгууллагын үйл ажиллагаанд холбогдох захирамжлалын баримт бичгийг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар болон www.erp.ulaanbaatar.mn цахим хуудсанд тус тус байршуулан нийт ажилтан, албан хаагчдад танилцуулсан.

Тайлант хугацаанд Монгол Улсын 5 хуулийн 8 заалт, Засгийн газрын 7 тогтоолын 17 заалт, Монгол Улсын Ерөнхий сайдын 1 албан даалгаврын 2 заалт, НИТХ-ын 2 тогтоолын

2 заалт, НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2 тогтоолын 2 заалт, НЗД-ын 13 захирамжийн 15 заалт, НЗД-ын зөвлөлийн хурлын 2 тэмдэглэлийн 2 заалтыг тус тус хяналтад авч хэрэгжилтийг ханган түүнд тогтмол хяналт тавьж ажиллалаа. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт 97%, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн холбогдох арга хэмжээний хэрэгжилт 98.7%, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2021-2025 оны хөгжүүлэх үндсэн чиглэлийн холбогдох арга хэмжээний хэрэгжилт 98%-ийн тус тус гүйцэтгэлтэй байна.

Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөний календарчилсан хуваарийн дагуу байгууллагын үйл ажиллагаанд давхардсан тоогоор нийт 12 удаагийн хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, зөрчил дутагдлыг арилгуулах хугацаатай зөвлөмж өгч ажиллалаа. Үүнд:

- НЗЗ-ны байруудад “Нөөц түлхүүр байршуулах, хүлээлцэх” журмын хэрэгжилт,
- Зоогийн газар, цайны газруудын үйл ажиллагаа;
- НЗЗ-ны байруудын цэвэрлэгээ үйлчилгээ;
- Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ;
- Инженерийн байгууламжийн ашиглалт, үйлчилгээний албаны үйл ажиллагаа;
- Үйлдвэрлэл, үйлчилгээний албаны үйл ажиллагаа;
- Байгууллагын болон нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Сэтгэл ханамжийн судалгааны талаар:

Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, хэрэглэгчдийн санал хүсэлтийг нээлттэйгээр хүлээн авч, хурдан шуурхай шийдвэрлэх зорилгоор сэтгэл ханамжийн судалгааг НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбарууд, Баянхошуу, Сэлбэ дэд төв, ННЗЦБ-нд үйл ажиллагаа явуулж байгаа нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдаас нийт 2 удаа цахим болон цаасан хэлбэрээр зохион байгуулсан. Судалгаанд нийт 868 ажилтан, албан хаагчид оролцож санал хүсэлтээ өгсөн. Тус судалгаанд оролцогчдын 67 хувь сайн, 29 хувь дунд, 4 хувь хангалтгүй гэж тус тус байгууллагын үйл ажиллагааг үнэлж дүгнэсэн.

3.2 Нийслэлийн засаг захиргааны байруудын инженерийн байгууламжийн ашиглалт, ус, дулаан, цахилгаан, хурлын танхимуудын техник, тоног төхөөрөмжийн хэвийн, найдвартай ажиллагааг ханган ажиллах чиглэлээр

Тайлант онд Нийслэлийн засаг захиргааны 5-н байранд байрлан төрийн үйлчилгээ үзүүлж буй Нийслэлийн нутгийн захиргааны 32 агентлагтай “Байр ашиглалтын гэрээ” болон “Гүйцэтгэх гэрээ” байгуулан гэрээний дагуу ажил, үйлчилгээг 24 цагаар тасралтгүй шуурхай үзүүлж, Нийслэлийн засаг захиргааны 5-н байр, Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн 4-н салбар, Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор байр, Баянхошуу, Сэлбэ дэд төвийн ус, дулаан, цахилгаан, мужааны засвар үйлчилгээг хийж, инженерийн байгууламжийн хэвийн найдвартай, жигд ажиллагааг ханган ажилласан.

Инженерийн шугам сүлжээг эвдрэл гэмтлээс урьдчилан сэргийлэх үзлэгийг албаны дарга сард 1 удаа, инженерүүд 14 хоног тутам тус тус тогтмол хийж, инженерийн байгууламжийн хэвийн ажиллагаанд хяналт тавьж, техникийн болзошгүй саатлаас урьдчилан сэргийлэх яаралтай засвар үйлчилгээг үзүүлэх ажлыг түргэн шуурхай зохион байгуулах, гамшгаас хамгаалах төлөвлөгөө, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах

төлөвлөгөө, Нийслэлийн засаг захиргааны байруудын хаврын тохижилтын ажлын төлөвлөгөөг тус тус боловсруулан, хэрэгжилтийг ханган ажилласан.

Тайлант хугацаанд инженерийн байгууламж, засвар үйлчилгээтэй холбоотой нийт 4164 дуудлагыг хүлээн авч эвдрэл гэмтлийн дуудлагыг шуурхай засварлаж ажилласан ба 2021 оны дуудлагын тоотой харьцуулахад 8%-иар буурсан үзүүлэлттэй байна.




График 7. Тайлант хугацаанд ИБАҮА-нд ирсэн нийт дуудлагын төрөл



График 8. Дуудлагыг өмнөх онуудтай харьцуулбал

Цахилгаан хангамжийн чиглэлээр:

Нийслэлийн засаг захиргааны байруудын цахилгааны шугам сүлжээний хэвийн ажиллагааг хангах, эвдрэл гэмтлээс урьдчилан сэргийлэх үзлэгийг тогтмолжуулах, ашиглалттай холбоотой нийт 1345 дуудлага ирснийг шуурхай шийдвэрлэн ажиллалаа.

Нийслэлийн засаг захиргааны 5-н байр, Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор байр, Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн 4-н салбар, Сэлбэ, Баянхошуу дэд төвийн цахилгаан эрчим хүчний тасралгүй ажиллагааг “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК”-тай хамтран ханган ажиллаж, доголдолгүй ажилласан. Тухайлбал:

- Нийслэлийн Засаг захиргааны 1, 2 дугаар байрны 0,4 квт-н ерөнхий щитэнд байрлах гүйдлийн трансформаторын баталгаажилтын хугацаа дууссаныг УБЦТС ТӨХК, Чингэлтэй дүүргийн хэрэглэгч үйлчлэх төв хүсэлт гарган 2000/5А, 300/5А-ын гүйдлийн трансформатор болгон сольж шинэчилсэн.
- Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор байрны хүндэтгэлтийн заалны щитний автомат, хэвлэл мэдээлэл байрлах өрөө рүү тэжээл татаж схемд оруулсан.

- Баянхошуу дэд төвийн халаалтын ерөнхий магистрал шугамын шахалтын насосыг шинэчлэн сольсон.
- НЗЗ-ны 2-р байрны ерөнхий АВР гэмтэл гарсныг шуурхай засварлаж, мөн давхруудад нийт 100 ширхэг лед гэрлийн цахилгааны монтаж хийж гүйцэтгэсэн.
- НЗЗ-ны 4-р байрны давхруудад 26 ширхэг галын хор, аюулгүйн самбар, цахилгааны монтаж хийж аюулгүй ажиллагааг хангасан.
- НЗЗ-ны 5-р байрны тайз, шумны өрөөнд 150 метр газардуулгыг шинээр татсан.
- НЗЗ-ны 1,2,5-р байр, Баянхошуу, Сэлбэ дэд төвийн гэмтэлтэй гэрэл чийдэнг лед гэрлээр сольж, эрчим хүчний зарцуулалтыг 10 хувиар бууруулсан.
- “Үндэсний их баяр наадам”, “Даншиг наадам-Хүрээ цам” шашин соёлын наадам, “Нүүдэлчин Монгол - 2022” соёлын биет бус өвийн их наадам, Өвөрхангай аймгийн Бүрд суман дахь Гэрэлт хөшөөнд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээний цахилгаан хангамжийн асуудлыг шийдсэн.
- Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд НЗЗ-ны байруудад дулааны хөшиг хийж гүйцэтгэсэн.



Зураг 11. Байруудын цахилгааны аюулгүйн үзлэгийн үеэр



Зураг 12. Байруудын цахилгааны засвар үйлчилгээ хийгдэж буй явцаас



Зураг 13. Гүйдлийн трансформаторыг сольж шинэчилсэн байдал

3.2.1 Сантехник, инженерийн шугам сүлжээний чиглэлээр:

Нийт байруудын сантехникийн шугам сүлжээ, агааржуулалтын хоолойн хэвийн найдвартай ажиллагааг ханган ажиллаж, нийт 1323 дуудлагыг бүртгэн тухай бүр шуурхай шийдвэрлэж ажилласан. Тухайлбал:

- Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд НЗЗ-ны 2-р байрны ариутгах татуургын ф100 хоолойд нийт 18м, НЗЗ-ны 4 байранд 7м ф100, НЗЗ-ны 5-р байранд 25м ф100мм хоолойд тус тус дулаалга хийж, хөлдөх эрсдэлээс урьдчилан сэргийлж, мөн Сэлбэ дэд төвд дулааны ф40мм тоолуурыг шинээр тавьсан.
- Нийслэлийн засаг захиргааны 3 дугаар байрны халаалтын болон хэрэгцээний усны гадна шугам хоолой хуучирч усны алдагдалтай байсныг шинэчлэн засварлаж хэвийн ажиллагаанд оруулсан.
- НТЗЦБ-ын А-4-р болкийн ариун цэврийн өрөөний агаар сорох сэнсний ороомог шатсан байсныг шинээр сольж, дулааны узельд коллекторын дулаалга, хаягжилт, агааржуулалтын сараалж, хэмжих хэрэгслийг хэвийн ажиллагаанд оруулсан.
- Зоогийн газрын холигч крант болон бохир ус зайлуулах сифон хоолойг шинэчлэн хэвийн аюулгүй ажиллагааг хангасан.
- Ашиглалтын баталгаат хугацаа дууссан хэрэглээний хүйтэн усны 2 ширхэг Ф15 тоолуурыг УСУГ-ын хэмжил зүйн лабораториор баталгаажуулсан.



Зураг 14. Дулаалга хийж буй явцаас



Зураг 15. Тоолуур шинэчилж буй явцаас



Зураг 16. Усны гадна шугам хоолойн засвар



Зураг 17. АЦӨ-ний сэнсийг засварлах үеэр



Зураг 18. Баянхошуу дэд төвийн АЦӨ-ний угаалтуурын холигчийг шинэчилсэн



Зураг 19. Байруудын ариун цэврийн өрөөний угаалтуурын холигчийг шинэчилсэн





Зураг 20. Драгон салбарын ариун цэврийн өрөөний угаалтуурын холигчийг засварласан



Зураг 21. 5-р байрны Б,В корпусын АЦӨ-ний угаалтуурын холигчийг засварласан



Зураг 22. Сэлбэ дэд төвийн дулааны тоолуурыг шинэчлэх явц



Зураг 23. Баянхошуу дэд төвийн эргэлтийн шугамын насос солих явцаас




График 9. Байруудын 2021 оны усны зарцуулалтыг харьцуулбал

Тайлант хугацаанд Нийслэлийн засаг захиргааны 2, 4-р байр болон Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор байрны хүн зөөврийн болон ачааны нийт 14 цахилгаан шатны хэвийн найдвартай үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж, сар бүр гэрээт байгууллагаар ашиглалт, засвар үйлчилгээг гүйцэтгүүлж, цахилгаан шатны магадлалыг жилд 1 удаа тогтмол хийлгэж лифтийн аюулгүй ажиллагааг ханган ажиллалаа.

3.2.3. Нийслэлийн засаг захиргааны байруудын хурлын танхим, хяналтын камеруудын техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангах чиглэлээр

НЗЗ-ны байруудын аюулгүй байдлыг хангах үүднээс жижүүр, харуул хамгаалалтын ажилтнууд камерын хяналтыг 24 цагийн турш хийж гүйцэтгэсэн. Тайлант хугацаанд харуул, хамгаалалттай холбоотой зөрчил, дутагдалгүй ажилласан. Тухайлбал:

- Байруудын 16 хяналтын камер, 3 ширхэг бичигч төхөөрөмжид /NVR/ засвар үйлчилгээг хийж, хэвийн ажиллагааг ханган ажилласан.
- Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор байр, Баянхошуу, Сэлбэ дэд төвд шинээр цаг бүртгэлийн нүүр царайгаар таньдаг төхөөрөмжийг шинээр суурилуулан сүлжээнд холбосон.

- Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор байранд BMS буюу автоматжуулалтыг хүлээн авч, агаар сэлгэлтийн 15 дэлгэцэд тохируулга хийж хэвийн ажиллагаанд хяналт тавьж, хяналтын камерын хянах дэлгэцэд байрлах камеруудыг IP хаягаар цэгцлэн оруулж, КНС, 0,4квт, генератор гэсэн 3 байрлалд шинээр камер суурилуулж тохиргоог хийж хэвийн ажиллагаанд оруулсан.
- Нийслэлийн засаг захиргааны 5Б байрны 1 камерын UTP кабелийг шинээр татаж, 5В байрны үүдэнд байрлах 1 камерын байрлалыг өөрчилж харах орчныг сайжруулж, 5А байрны 1 NVR-ийн тэжээлийн тог баригч шатсаныг шинээр сольж, гадна камерын UTP кабелийг STP кабелиар сольж хэвийн ажиллагаанд оруулсан. Нийслэлийн засаг захиргааны 3-р байранд 2 ширхэг камер шинээр нэмж суурилуулсан.
- Нийслэлийн засаг захиргааны 2 дугаар байрны 14 давхарт байрлах А танхимын дэлгэцийн дуу дүрсний HDMI кабелийг шинээр сольж дүрсний хэвийн ажиллагааг хангасан.
- Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор байрны А1, А2, А3, А4 блокуудын 6 серверийн өрөө, ослын шатны орох гарах гарц, хаалганы нэвтрэх системийн программыг гүйцэтгэгч “Темпланд” ХХК-аас хүлээн авч 4 ic карт шарж 2 менежер, 2 инженерт хүлээлгэн өгсөн.



Зураг 24. Камер засвар үйлчилгээний явцаас

Тайлант хугацаанд НИТХ, НЗД-н шуурхай, НЗД-ын зөвлөлийн хурал, хүндэтгэлийн арга хэмжээ болон бусад хурлын үйл ажиллагаанд ашиглагдах тоног төхөөрөмжийн бэлтгэл ажил бэлэн байдлыг хангаж, ямар нэгэн доголдолгүй хэвийн явуулах нөхцөлийг бүрэн хангаж ажиллалаа. Байгууллагын www.Khangardi.mn цахим хуудсыг хөтлөлт, хөгжүүлэлтийг тухай бүр нь хийж, мэдээллийн болон техникийн аюулгүй байдлын ханган ажиллаж, аливаа цахим халдлагаас урьдчилан сэргийлж ажилласан.

Тайлант онд 4 байршилд нийт 1460 арга хэмжээ буюу НЗДТГ буюу НЗЗ-ны 1 дүгээр байрны хурлын зааланд 767 арга хэмжээ үүнээс НЗЗ-ны 2-р байр буюу Хангарди ордны 14 давхрын хурлын танхимд нийт 553 арга хэмжээ, НЗЗ-ны 5-р байрны В корпусын хурлын танхимд нийт 135 арга хэмжээ, Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор төв байрны хурлын танхимд нийт 5 арга хэмжээг тус тус зохион байгуулагдаж, дээрх арга хэмжээний техник, тоног төхөөрөмжийн бэлтгэл ажлыг тухай бүр хангаж, ямар нэгэн зөрчил, доголдолгүй хэвийн жигд ажиллагааг хангаж ажиллаа. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зохион байгуулагдсан хурлын тоо 1.2 дахин өссөн нь коронавирусын түвшнийг бууруулж энгийн нөхцөл байдалд шилжсэнтэй холбоотой байна.

Байруудын хурлын заалны захиалгыг цахим хэлбэрээр авч, мэдээллийн ил тод нээлттэй байдал, хэрэглэгчдийн цаг хугацааг хэмнэх зорилгоор холбогдох хөгжүүлэлтийн багтай хамтран нийслэлийн нутгийн захиргааны дотоод удирдлагын

www.erp.ulaanbaatar.mn системд “Хурлын заал захиалгын систем” нэртэй нэмэлт цэс оруулж хөгжүүлэлтийг 100 хувь хийж гүйцэтгэн үйлчилгээнд нэвтрүүлэхэд бэлэн болгосон.



Зураг 25. Нэрийг үндэсний бичиг, кирилл үсгээр хослуулсан хаягжуулсан

Зураг 26. Хурлын заалны захиалга цахимаар хүлээн авах цэс




График 10. 2022 онд 4-н байршлын хурлын тоог харьцуулбал

3.2.4. Нийслэлийн засаг захиргааны байруудын засвар үйлчилгээний чиглэлээр

Тайлант онд нийслэлийн засаг захиргааны байрууд, дэд төвүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан орц, гарцыг сайжруулах, засварлах, орчин нөхцөлийг бий болгохоор иргэдэд зориулсан тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу бүрэн хийж гүйцэтгэсэн ба нийслэлийн засаг захиргааны 5-р байрны В корпус, нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор байрны А4 - В1 давхрын ариун цэврийн өрөөнүүд, болон Сэлбэ дэд төвд шинээр 2 ариун цэврийн өрөөг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан стандартын дагуу шинэчилж иж бүрэн тохижуулж ажиллалаа. Мөн Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор байрны гадна орчны талбайд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан 4 гарцыг стандартын дагуу хийж гүйцэтгүүлсэн.

Нийслэлийн засаг захиргааны 2 дугаар байр буюу Хангарди ордны 2, 4, 9, 11, 12, 13,14 давхрын өрөөнүүдэд засварын ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн тус байрны хүн зөөвөр болон ачааны лифтний шалны хуучирсан хулдаасыг шинэчлэн сольсон.



Зураг 27. Засвар хийхээс өмнө болон дараах байдал



Зураг 28. Лифтний шалны хуучирсан хулдаасыг шинэчилсэн байдал

Дулааны улирал эхэлсэнтэй холбоотойгоор мэргэжлийн байгууллагатай хамтран Нийслэлийн засаг захиргааны 2 дугаар байрны 1-16 давхрын агааржуулалтын системийн горимыг өөрчилж схемд холбон, ээлжит цэвэрлэгээ үйлчилгээг хийж гүйцэтгэсэн.



Зураг 29. Агааржуулалтын системийн горимыг схемд холбож буй явцаас

Нийслэлийн засаг захиргааны 3 дугаар байрны 3 дугаар давхарт байрлах галын системийн шугам хоолой олон жилийн элэгдэл хорогдлоос болж хуучирч ус алддаг байсныг засварласан. Тус байрны подвалын давхарт байрлах нийтийн эзэмшлийн ариун цэврийн өрөөг шинэчлэн засварлаж, иргэдийг тав тухтай орчинд үйлчлүүлэх орчин нөхцөлөөр ханган ажиллалаа.



Зураг 30. Засвар хийхээс өмнө болон дараах байдал

Сэлбэ дэд төвийн 1 давхрын хана, өлгүүрийн өрөө, хяналтын өрөө зэрэг 119.68 м² талбайд засвар хийж өнгө үзэмжийг сэргээсэн.



Зураг 31. Сэлбэ дэд төвийн өрөөний ханыг засварын үеэр

Зураг 32. НЗЗ-ны 3-р байрны АЦӨ-ний засварын явцаас




Зураг 33. Сэлбэ дэд төв, НЗЗ-ны 5В байрны АЦӨ-г тохижуулсан байдал

Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор байрны А3, А4 блокийн дээврээс шар усны дусаал гоожсон шалтгааныг тогтоож, засвар үйлчилгээ хийж, А4-В1 давхрын ариун цэврийн өрөөнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний ариун цэврийн өрөөг иж бүрэн тохижуулсан. Мөн үйлчилгээ, инженер техникийн ажилтан, албан хаагчдын ажлын болон амралтын өрөөний тусгаарлалтыг хийж, хэвийн ажиллах нөхцөл бололцоогоор ханган ажилласан.



Зураг 34. Дээврийн засварын үеэр



Зураг 35. АЦӨ-г бүрэн тохижуулсан байдал



Зураг 36. Өрөөнүүдийг тусгаарлалт хийж бэлэн болгосон байдал



Зураг 37. НЗЗ-ны 4 болон 5В байрны дээврийн засварын явцаас



Зураг 38. Баяр наадмын арга хэмжээний үеэр нүүлгэлт хийх, гэр барих үеэр

3.3. Нийслэлийн Засаг захиргааны байруудын цэвэрлэгээ, үйлчилгээ, эрүүл ахуйд нийцсэн зоогийн үйлчилгээ, хурлын заалны цайны завсарлага үйлчилгээний чиглэлээр:

3.3.1 Нийслэлийн Засаг захиргааны байруудын цэвэрлэгээ үйлчилгээ

Тайлант хугацаанд байгууллагын “Нутгийн захиргааны байгууллагуудын цэвэрлэгээ үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага” UCS0201B удирдамж арга зүйн баримт бичгийг баримтлан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Нийслэлийн засаг захиргааны 5-н байр, Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн 4-н салбар, Баянхошуу, Сэлбэ дэд төв, Хотын захиргааны шинэ цогцолборын А блок буюу нийт 61.395м.кв талбайн өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээ үзүүлж, 7920 удаа, ариун цэврийн өрөөний цэвэрлэгээг 7920 удаа, хуваарийн дагуу их цэвэрлэгээг 720 удаа тус тус хийж гүйцэтгэсэн. Байгууллагын цахим хуудсанд өдөр бүр ажлын үйл явц байдлыг байршуулан, ажлын гүйцэтгэлд байр хариуцсан менежерүүд давхар хяналт тавьж хэрэгжилтийг ханган ажилласан. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээ 30 хувиар, их цэвэрлэгээ 10.4 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.



Зураг 39. Өдөр тутмын цэвэрлэгээ, үйлчилгээ хийж буй явцаас



Зураг 40. Нийтийн эзэмшлийн талбайн өдөр тутмын цэвэрлэгээний үеэр



Зураг 41. Нийтийн эзэмшлийн талбайн их цэвэрлэгээний үеэр



Зураг 42. Наадмын бэлтгэл ажлын асрын цэвэрлэгээ хийгдэж буй байдал

Тайлант хугацаанд цэвэрлэгээ, үйлчилгээний чанарыг сайжруулах, хөдөлмөрийг хөнгөвчлөх үүднээс 11.800,000 төгрөгийн үнэ бүхий тоос сорогч, хагас автомат шал угаагч, ажилчдын хувцас зэрэг шаардлагатай хэрэгсэл, техник тоног төхөөрөмжөөр ханган ажиллалаа.



Зураг 43. Ажилчдын шинэчилсэн ажлын хувцас

“Хогоо ангилж хэвшүүлцгээе” уриатайгаар нийслэлийн засаг захиргааны байруудад хог хаягдлыг ангилан ялгах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэн хэвшүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байгаа билээ. Энэ хүрээнд дахивар нөөцийг ангилан ялгаж картон цаас болон хуванцар савыг төрөлжүүлэн ангилж, нийлүүлэн ажиллаж байна.



Зураг 44. Хог ангилах савыг сэргээн засварласан байдал

Мөн Эрүүл мэнд, нийгмийн бодлогын хүрээлэнтэй хамтран “Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, ангилан ялгах” сэдэвт давтан сургалтыг 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр цахимаар зохион байгуулж, нийт 12 байршлаас 125 ажилтан, албан хаагч тус арга хэмжээнд хамрагдаж өмнөх мэдлэгээ бататгаж, шинээр орсон ажилчдад хог ангилан ялгах мэдлэгийг олгон ажиллалаа.

Байруудын гадна орчны цэвэрлэгээ үйлчилгээний талаар

Нийслэлийн засаг захиргааны байруудын гадна орчны аюулгүй байдлыг ханган өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээг хийж гүйцэтгэн тухайн байруудын гаднах нийтийн эзэмшлийн зам талбайг халтиргаа гулгаанаас урьдчилан сэргийлж, орчны 50 метр хүртэлх 31,450 м² талбайн цас, мөс цэвэрлэх, өдөр тутмын болон дээврийн их цэвэрлэгээг нийт 168 удаа, их цэвэрлэгээг 672 удаа тус тус хийж, жилийн эцсийн

байдлаар нийт 3696 удаа гадна талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хийж хэрэгжилтэд, хяналт тавьж ажиллалаа.



Зураг 45. Гадна талбайн их цэвэрлэгээний үеэр



Зураг 46. Гадна талбайн их цэвэрлэгээг хийж буй байдал



Зураг 47. Байруудын гадна талбайн их цэвэрлэгээний явцаас

Тохжилт, үйлчилгээний талаар:

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар нь Нийслэлийн засаг захиргааны байрууд, Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн салбарууд, Баянхошуу, Сэлбэ дэд төв, Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор байрны цэвэрлэгээ үйлчилгээг хариуцан ажиллахын зэрэгцээ төрийн албан хаагчдын ажиллах ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр байруудын гадна болон дотор талын тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Нийслэлийн засаг захиргааны байруудын гадна талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлж, орчны тохижилтыг сайжруулах зорилгоор Нийслэлийн засаг захиргааны байруудын гадна талбайд цэцгийн мандал, зүлэгжүүлэлтийг хийсэн. Тухайлбал:



Зураг 48. Ногоон байгууламж, гадна тохижилтын ажлын явц



Зураг 49. Байруудын гадна талбайн цэвэрлэгээний үеэр

3.3.2 Хоол, зоогийн үйлчилгээ

Хангарди ордны зоогийн газар, НЗДТГ, Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор байр, Улаанбаатар театрын цайны газруудаар нийтийн хоол, хүндэтгэлийн хүлээн авалт, цай завсарлага, катерингийн үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэн ажиллаж байна. Байгууллагын зоогийн газрын хүнсний бараа материалын 90 хувийг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг худалдан авч, төрийн албан хаагчдад эрүүл, чанартай хүнсний бүтээгдэхүүнээр хоол, зоогийн үйлчилгээг үзүүлж ажиллалаа.

Эрүүл чанартай хоол хүнс бэлтгэх, хүнсний бараа материалыг гэрээний дагуу худалдан авахдаа эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангах зорилгоор хүнсний бүтээгдэхүүний гарал үүслийн бичиг, шинжилгээний бичгийн хамт хүлээн авдаг ба хадгалалтын горимд “Хоолны газрын нийтлэг журам”-ыг мөрдөн ажиллаж, зоогийн газар, цайны газруудын ажилтнуудыг Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд нийт 2 удаа давхардсан тоогоор 53 ажилтныг хамруулан хоол хүнсний эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажилласан. Зоогийн газарт тавигдах зоогийн газрын ажилчдын өдөр тутмын хувийн ариун цэвэр, хөргөгч хөлдөөгчийн температурын хяналт зэрэг 7 төрлийн бүртгэл хөтлөлтийг хийж, хэрэгжүүлэн ажилласан.



Зураг 50. Өглөөний цай, хүлээн авалтын хоолны шинэ нэр төрлөөс

Нийтийн хоолны үйлчилгээний талаар:

Тайлант хугацаанд Хангарди ордны зоогийн газар 11326, НЗДТГ-ын цайны газар 15523, Нийслэлийн засаг захиргааны 5-р байрны цайны газар 6571, Нийслэлийн нутгийн

захиргааны цогцолбор байрны цайны газраар дамжуулан 17151, Нийслэлийн онцгой комиссын албан хаагчдад өдөрт 3 удаа буюу 2631 нийт давхардсан тоогоор 53202 орчим хүнд нийтийн хоолны үйлчилгээг стандартын дагуу, эрүүл, чанартай хүнсээр бэлтгэн, мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэн, тайлант онд нийт 1.047.436.1 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн.

Хоолны технологийн картыг шинэчлэн өдөр тутмын хоолны цэсийг улирлын онцлогт тохируулан зууш салат - 20, хачир сүмс - 8, нэгдүгээр хоол - 20, хоёрдугаар хоол – 40, өглөөний цай – 10 буюу нийт 98 төрлөөр боловсруулж, зоог, цайны газруудад мөрдөж, хоол үйлдвэрлэлд мөрдөгдөх бүртгэлийн маягтуудыг 9 төрлөөр тогтмол хөтлөн ажилласан.

Зоогийн газраас гарч буй бүтээгдэхүүний хоолны сав, баглаа боодлыг стандартын шаардлага хангасан материалаар хийсэн хүнсний эрүүл ахуйн шаардлагыг хангасан хэрэглэгдэхүүн хэрэглэж, хүлээн авалтын ширээ засалт түүнд хэрэглэгдэх зүйлсийн жагсаалт гаргаж зарим дутагдалтай эд зүйлсийг үе шаттайгаар худалдан авч, хоол үйлдвэрлэлд хэрэглэгдэж буй түүхий эдийн чанарт анхаарч, хадгалалтын горимыг мөрдүүлэн ажиллаж, шаардлагатай эд зүйлсийг нэмэгдүүлэн ажиллалаа. Мөн мэргэжлийн байгууллагаар зоог, цайны газруудын усны шинжилгээг шинжлүүлж, хоол, зоогийн үйлдвэрлэл үйлчилгээ явуулах батламжийг сунгуулсан.

Хүлээн авалтын үйлчилгээний талаар:

Тайлант хугацаанд зоогийн хүлээн авалтыг 136 удаа нийт 8826 хүнд, хурлын цайны завсарлага 57 удаа нийт 4513 хүнд, нийт 13339 хүнд шуурхай чанартай үйлчилгээг үзүүлж ажилласан ба үйлчилгээтэй холбоотой санал гомдол гараагүй байна.

Тайлант онд зохион байгуулагдсан томоохон хүлээн авалт, хээрийн зоогийн үйлчилгээг мэргэжлийн түвшинд дараах байдлаар гүйцэтгэн ажилласан. Үүнд:

- Ардын хувьсгалын 101 жилийн ой, Үндэсний их баяр наадмаар 2022 оны 07 дугаар сарын 11-ний өдрөөс 2022 оны 07 дугаар сарын 13-ны өдрийн хооронд хүндэтгэлийн хүлээн авалтын зоогийн үйлчилгээг Хүй 7 худагт 3 байршилд, Төв цэнгэлдэх хүрээлэнд 2 тусгай өрөөнд буюу 5 байршилд нийт 4150 зочид төлөөлөгчид;
- “Даншиг наадам-Хүрээ цам” шашин соёлын наадмаар 2022 оны 08 дугаар сарын 06-ны өдрөөс 2022 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн хооронд хүндэтгэлийн хүлээн авалтын зоогийн үйлчилгээг Хүй 7 худагт 2 байршилд нийт 620 зочид төлөөлөгчид;
- “Нүүдэлчин Монгол - 2022” соёлын биет бус өвийн их наадмаар 2022 оны 08 дугаар сарын 12-ны өдрөөс 2022 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн хооронд хүндэтгэлийн гэрт тусгай үйлчилгээг Горхи-Тэрэлжид нийт 310 зочид төлөөлөгчид;
- Нийслэл хот үүсэн байгуулагдсаны түүхт 383 жилийн ойг тохиолдуулан Өвөрхангай аймгийн Бүрд сумын нутагт байрлах нийслэлийн анхны шавыг тавьсан гэрэлт хөшөөнд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд 2022 оны 09 дүгээр сарын 09, 10-ны өдрүүдэд хээрийн үйлчилгээг нийт 1550 зочид төлөөлөгчид;
- Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарын 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр UB place-д зохион байгуулсан “Шинэ сэргэлтийн бодлого” арга хэмжээний вип өрөөний хурлын цайны завсарлагын үйлчилгээ;



Зураг 51. Баяр наадмын арга хэмжээний хүлээн авалтын үеэр

Мөн Нийслэлийн Засаг захиргааны 2 дугаар байрны Хангарди зоогийн газрын зааланд борооны ус гоожсоны улмаас тааз, хана, шал гэрэлтүүлэг гэмтснийг шинэчлэн засаж, тохижилтын ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн.



Зураг 52. Зоогийн газарт засвар хийхээс өмнөх болон дараах засварласан байдал

3.3.3 Хурлын заалны ашиглалт, үйлчилгээний чиглэлээр:

Тайлант хугацаанд хуралдааны танхимд явагдах арга хэмжээний захиалгыг урьдчилан авч, график хуваарьт оруулан, хуваарийн дагуу хөнгөн шуурхай, чанартай үйлчилгээ үзүүлж ажилласан. Хангарди ордны хурлын танхимуудад нийт 1416 удаагийн үйлчилгээг үзүүлсэн байна.



Зураг 53. Хурлын цай завсарлагын үйлчилгээний үеэр

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ
3Г-ын 2020 оны 206 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралт

Хүснэгт 6

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал			
1.	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Тус газар нь байгууллагын дунд, богино хугацааны төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахдаа байгууллагын эрхэм зорилго, дүрмээр хүлээсэн чиг үүрэгт нийцүүлэн боловсруулж, тэдгээрийн хэрэгжилт, үр дүнг тухай бүр нь байгууллагын цахим хуудаст шинэчлэн байршуулж ажиллаж байна. http://khangardi.mn/?page_id=3648 http://khangardi.mn/?page_id=3634 Мөн Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан байгууллагын бүтэц, зохион байгуулалтын схемийг мэдээллийн самбар, цахим хуудаст тогтмол байршуулж ажилласан. http://khangardi.mn/?page_id=3868	100%
2.	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Тус газрын албан хаагчдын холбоо барих утас, холбогдох бусад мэдээлэл, иргэд хүлээн авч уулзах цагийн хуваарийг байгууллагын цахим хуудаст байршуулж, тогтмол шинэчилж ажиллалаа. http://khangardi.mn/?page_id=3668 http://khangardi.mn/?page_id=3672 http://khangardi.mn/wp-content/uploads/2021/03/005.jpg	100%
3.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль, журам эрх зүйн актыг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулж, тогтмол шинэчилж ажиллалаа. http://khangardi.mn/?page_id=4047	100%
4.	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	Тайлант хугацаанд Дорноговь аймгийн нийтлэг үйлчилгээний газрын хамт олонд 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдөр, Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын Аж ахуйн тасгийн хамт олонд 2022 оны 03 сарын 14-ний өдөр UCS0202B:2020 "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын цэвэрлэгээ, үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага" удирдамж арга зүйн баримт бичгийг танилцуулан сурталчлан ажиллалаа.	100%
Хэсгийн дундаж хувь:			100%
Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал			
1.	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;	Сул орон тооны зарыг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, www.unegui.mn цахим хуудас болон нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар, дүүргүүдийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдэд нээлттэй зарлан ажилласан. Тайлант онд 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдөр "Бүтээлч Баянголчууд" нээлттэй өдөрлөг, 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр "Ажилтай	100%

		орлоготой залуус” өдөрлөг, 2022 оны 11 дүгээр сарын 28-ний өдөр “Эх орондоо хөдөлмөрлөх боломж 2022” 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдөр “Ажил олгогчдын уулзалт” форумд тус тус оролцсон. Мөн Барилгын политехникийн коллежид 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдөр, НҮНТ-ийн Дүнжингарав салбарын гадна талбайд 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдөр, Хан-Уул дүүргийн 16 дугаар хороонд байрлах Хаан банкны гадна талбайд 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр тус тус нээлттэй ажлын байрны өдөрлөгийг зохион байгуулж, байгууллагын чиг үүрэг, үндсэн үйл ажиллагаа танилцуулан сурталчлан, ажлын байрны сул орон тоог нээлттэй зарлан ажилласан.	
2.	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Тус газрын ажилтны ёс зүйн дүрмийг цахим хуудас, мэдээллийн самбарт тогтмол байршуулж ажилласан. http://khangardi.mn/?page_id=4047	100%
3.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа дүрэм, журмыг байгууллагын цахим хуудаст тогтмол байршуулан ажилласан. http://khangardi.mn/?page_id=4047	100%
4.	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлээр ажлын байрны сул орон тооны зарыг 14 хоног тутам буюу нийт 24 удаа байгууллагын цахим хуудас www.khangardi.mn , зарын нэгдсэн цахим хуудас www.unequi.mn , www.biznetwork.mn болон байгууллагын мэдээллийн самбарт тус тус тогтмол байршуулж ажиллалаа. Мөн Хөдөлмөр эрхлэлтийн газар, дүүргүүдийн Хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтэст ажлын байрны сул орон тооны зарыг 14 хоног тутам буюу нийт 24 удаа хүргүүлж ажиллалаа. http://khangardi.mn/?page_id=3583	100%
5.	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	Ажилтан, албан хаагчдын ур чадварыг холбогдох журмын дагуу улирал бүр дүгнэж, ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу ур чадварын нэмэгдлийг сар бүр олгон ажилласан ба дүгнэх журам, дүгнэсэн байдлыг цахим хуудаст тухай бүр нь байршуулж ажиллалаа. Мөн ажилтан, албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх ажлыг байгууллагын Үнэлгээний баг улирал бүр Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолын дагуу зохион байгуулж, холбогдох арга хэмжээг авч ажилласан ба энэ талаар мэдээ, мэдээллийг цахим хуудаст байршуулж ажилласан. http://khangardi.mn/?page_id=3613	100%
Хэсгийн дундаж хувь:			100%

ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД ЦАГ ҮЕИЙН АЖЛЫН ХЭРЭГЖИЛТ

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Мартын 8-ны өдрийг тохиолдуулан байгууллагын эмэгтэй ажилтан, албан хаагчдад зориулсан хүндэтгэлийн арга хэмжээг 2022 оны 03 дугаар сарын 06-ны өдөр зохион байгууллаа. Тус арга хэмжээний үеэр нийт ажилтан, албан хаагчдын дунд зохион байгуулсан “Ээждээ захидал бичээрэй” уралдааны шилдэг 3 оролцогчдыг шалгаруулж, оролцогчдод өргөмжлөл, мөнгөн шагналыг гардууллаа.



Зураг 54. Шагнал гардуулах арга хэмжээний үеэр

Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 55 дугаар захирамжаар Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 31.2 дахь хэсэгт заасны дагуу газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/27 дугаар тушаалаар ажлын хэсэг томилогдож хуулиар зөвшөөрснөөс бусад мэдээлэл хариуцагчийн цуглуулсан биеийн давхцашгүй өгөгдлийг устгах үйл ажиллагааг зохион байгуулж, нийслэлийн засаг захиргааны 4-н байрны нийт 154 ажилтан, албан хаагчдын хурууны хээ агуулж буй файл, өгөгдлийн баазыг устгаж, давтагдашгүй хувь хүний биометрик өгөгдөл болох нүүр царайгаар таниулах системд шилжүүлэн шинэчилсэн.



Зураг 55. Төхөөрөмжийг шинэчлэх үеэр

Монгол Улсын Ерөнхий сайд, Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн тэргүүний 2021 оны 01 дугаар тогтоол, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/72 дугаар тушаалаар залуучуудыг дэмжих, залуу хосуудад гэр бүлийн боловсрол олгох, амьдралд бэлтгэх зорилгоор 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдөр 4-н залуу гэр бүл, гал голомтоо бадрааж, дээрх арга хэмжээнд байгууллагын зүгээс дэмжлэг үзүүлэн ажиллалаа.



Зураг 56. Гэрлэх ёслолын үеэр

Тайлант хугацаанд 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Дорноговь аймгийн нийтлэг үйлчилгээний газрын хамт олонд, Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын Аж ахуйн тасгийн хамт олонд 2022 оны 03 сарын 14-ний өдөр тус тус UCS0202B:2020 "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын цэвэрлэгээ, үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага" удирдамж арга зүйн баримт бичгийг танилцуулан сурталчилж ажиллалаа.



Зураг 57. Туршлага солилцох арга хэмжээний үеэр

Монгол Улсын Ойн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийн хүрээнд хэрэгжүүлэх "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд "Ногоон хот-Иргэний оролцоо" хаврын мод тарих аян зохион байгуулагдсан. Тус аяны хүрээнд 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдөр "Баянгол цэцэрлэгт хүрээлэн"-д 170 ширхэг хайлаас мод тарьж, модны арчилгаа, усалгааг хийж гүйцэтгэлээ.



Зураг 58. Ажилтан, албан хаагчид мод тарьж байгаа байдал

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх хүсэл, сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор "Улаанбаатар Марафонд нэгдэцгээе" нийслэлийн Засаг даргын нэрэмжит цомыг аялан явах хуваарийн дагуу 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Нийслэлийн Нийтийн тээврийн газраас хүлээн авч, 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр Нийслэлийн Онцгой байдлын газарт хүлээлгэн өгсөн.



Зураг 59. Аяны цомыг хүлээн авч, хүлээлгэн өгч буй үеэр

Долоо дахь жилдээ зохион байгуулагдаж буй “Улаанбаатар Марафон - 2022” олон улсын гүйлт 2022 оны 05 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулагдаж, тус арга хэмжээнд байгууллагын нийт 28 ажилтан, албан хаагч идэвхтэй оролцсон.



Зураг 60. Олон улсын гүйлтийн тэмцээний үеэр

Төрийн албан хаагчдын ажиллах ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэх, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх талаар ажилтан, албан хаагчдаас гаргасан шинэ санал санаачилгыг дэмжин идэвхжүүлэх зорилгоор Нийслэлийн засаг захиргааны байруудад ажиллаж байгаа үйлчилгээ, техникийн ажилтнуудын дунд “Ногоон орчин” сэдэвт болзолт уралдааныг 2022 оны 04 дүгээр сарын 20-ний өдрөөс 05 дугаар сарын 16-ны өдрүүдэд 1 сарын хугацаатайгаар зарласан. Уралдаанд 13 баг оролцож өөрсдийн байруудын онцлогт тохируулан гадна болон дотор талын тохижилт, цэцэгжүүлэлт, зүлэгжүүлэлт, засвар үйлчилгээг өөрсдийн нөөц бололцоогоор хийж гүйцэтгэсэн.



Зураг 61. Шалгарсан хамт олон

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан байгууллагын эцэг, эхийн зөвлөлөөс байгууллагын ажилтан, албан хаагчдын хүүхдүүдийн дунд 2022 оны 05 дугаар сарын 16-25-ны өдрийн хооронд 3 насны ангиллын 3 төрлөөр буюу гар зураг, баримлын шавраар бүтээл хийх, илтгэлийн уралдаан зэргийг зохион байгуулж, нийт 33 хүүхдийн бүтээл ирснийг удирдамжийн дагуу уран сэтгэмж, авьяас чадвар, мэдлэг оюунаа сорин оролцож шалгарсан 9 хүүхдийн бүтээлийг шалгаруулж урамшуулсан.



Зураг 62. Шалгарсан хүүхдүүд бүтээлүүдээс

Байгууллагын ажилтан, албан хаагчдын хүүхдүүдээс сурлага, урлаг, спортоороо амжилт гаргасан шилдэг хүүхдүүдийг А.Энхжин, Б.Маралмаа Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын нэрэмжит “Алтан медаль”-иар шагнасан.



Зураг 63. Шагнал гардуулах үеэр

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газраас нийгмийн хариуцлагын хүрээнд сайн дурын, авлагагүй, цусны донорын эгнээг өргөжүүлэх, цусны донорын үйлсийг сурталчлах зорилгоор Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газартай хамтран “Цусаа бэлэглэе” сайн үйлсийн аяныг 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор байранд амжилттай зохион байгуулсан.

Арга хэмжээнд тус байран байрлан үйл ажиллагаагаа явуулж байгаа нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын нийт 50 гаруй төрийн албан хаагч хамрагдаж 150 хүнд амьдрал бэлэглэх их үйлсэд нэгдсэн.



Зураг 64. Цус хандивлах аяны явцаас

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төрийн албан хаагчдыг хамруулан ажлын байран дахь харилцаа хандлага, цэвэрлэгээ, үйлчилгээг чанартай гүйцэтгэхэд тэдгээрийн оролцоог нэмэгдүүлэх, зорилгоор 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн хугацаанд “Та цэгцэл - Бид үйлчилнэ” аяныг зохион байгуулсан. Аяны хүрээнд ажлын байрны соёл, ажлын байран дээрх эмх цэгцийг сайжруулах 5S зарчмыг нэвтрүүлэн мөрдүүлж ажилласан.



Зураг 65. Албан хаагчдыг аянд нэгдэхийг уриалж, танилцуулах материал тараах үеэр

Нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны 383 жилийн ойн өдрийг тохиолдуулан НЗЗ-ны 5-н байр, НҮНТ-ийн 4-н салбар, Баянхошуу, Сэлбэ дэд төвүүд болон Нийслэлийн нутгийн захиргааны цогцолборын нийт ажилтан, албан хаагчид, үйлчилгээ авч буй иргэдэд хүндэтгэл үзүүлж ажиллалаа.



Зураг 66. Төрийн албан хаагч, иргэдэд баярын мэндчилгээ дэвшүүлж буй үйл явдлын явцаас

“Нандин бүхнээ хамгаалъя - Өөрийгөө, гэр бүлээ, орчин тойрноо” урианы дор 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян”-д байгууллагын нийт ажилтан, албан хаагчид нэгдэн 15-н байршилд нэгдсэн зохион байгуулалттайгаар энгэртээ цагаан тууз зүүж “Охид эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй хүчирхийллийн хажуугаар дуугүй өнгөрөхгүй, хэзээ ч хүчирхийлэл үйлдэхгүй” гэж амлалт өгөх хөдөлгөөнд идэвх санаачилгатай оролцлоо.



Зураг 67. Аянд нэгдэж цагаан тууж зүүж илэрхийлсэн байдал

Монгол Улсад нийтийн аж ахуйн салбар үүсэж хөгжсөний 91 жилийн ойг тохиолдуулан ажил хөдөлмөрөөрөө манлайлан, идэвх зүтгэлтэй ажилласан албан хаагчдыг Засгийн газар, салбар яамд, Төр, засгийн үйлчилгээ эрхлэх газар, НИТХ болон НЗД-ын шагналаар тус тус шагнаж урамшууллаа.



Зураг 68. Шагнал гардуулах арга хэмжээний үеэр

ЗУРГАА. ДҮГНЭЛТ


Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2021-2025 оны хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөвлөгөөтэй уялдуулан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагааны хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд нутгийн захиргааны байгууллага болон төрийн албан хаагчдад үзүүлэх төрийн үйлчилгээний чанар стандартад нийцсэн нийтлэг үйлчилгээг үзүүлж, үр дүнг тооцож ажилласан.

Тайлант хугацаанд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллаж, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, төсөв санхүүгийн сахилга батыг ханган ажиллалаа.


Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар нь ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудал, сурч боловсрох, тэдний ажиллах нөхцөл боломжийг сайжруулахад анхааран хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ, үйл ажиллагаагаа бүрэн хангалттай хэрэгжүүлж ажилласан.

Манай байгууллага нь тайлант хугацаанд дүрмээр хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэн ажиллаж, цаг үеийн шинж чанартай дээд газраас зохион байгуулсан арга хэмжээнд идэвх санаачилгатай хамрагдан, өгөгдсөн үүрэг чиглэлийг үр дүнтэй, амжилттай биелүүлэн ажиллалаа.


ТАНИЛЦСАН:
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Л.ДЭЛГЭР

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА


Ч.ШИНЭЧИМЭГ

ТАЙЛАН БИЧСЭН:
ТӨЛӨВЛӨЛТ, ТАЙЛАН МЭДЭЭ
ХАРИУЦСАН АЖИЛТАН


Ц.ҮРЭЛМАА